

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

БАТЛАВ.

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ /Б. БУЯННЭМЭХ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН.

“НИТРО СИБИРЬ МОНГОЛИА” ХХК -ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /Ц. СОЁЛ-ЭРДЭНЭ/



“НИТРО СИБИРЬ МОНГОЛИА” ХХК-ИЙН

**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 03-Р ХОРООНЫ БАЯН УУЛ НУТАГ
ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХ ЦОГЦОЛБОРЫН**

2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 5737079/

Хянасан:

БОАЖЯ-ны хүрээлэн буй орчин, байгалийн
нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн

/Л.ШИНЭЦЭЦЭГ/

Боловсруулсан:

“НИТРО СИБИРЬ МОНГОЛИА ХХК”-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуй, байгаль орчны ажилтан

/Г. ХҮСЛЭН/

2023

**“ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР АГУУЛАХЫН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БҮЛЭГ 1

- Төслийн товч танилцуулга
- Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

БҮЛЭГ 2

- Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

БҮЛЭГ 3

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
- Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
- Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийг хэрэгжүүлэгч:

НИТРО СИБИРЬ МОНГОЛИА ХХК “Үйлдвэрлэлийн зориулалттай энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр агуулахын цогцолбор”

Төслийн нэр:

“Тэсрэх бодисын үйлдвэр агуулах”

Улсын бүртгэлийн дугаар:

9011647051

Регистрийн дугаар:

5737079

Төслийн байршил:

Улаанбаатар хотын Налайх дүүргийн Баян-Уулын зүүн хойно 3-р хорооны нутагт байрлах энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор

ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ


Төсөл хэрэгжүүлэгчийн байршил:

Үйлдвэрлэлийн зориулалттай нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн Баян-Уулын зүүн хойно 3-р хорооны нутагт байрлах ба төслийн талбайгаас баруун хойд хэсэгт 2.6 км зайд “Бласт” ХХК-ны үйлдвэрийн барилга байгууламж байх ба зүүн хойшоо “Бумбатын гол” ХХК-ийн үйлдвэр 1.6 км зайд байрлана.


Зураг 1 Үйлдвэрийн эдэлбэр газрын булангийн цэгүүдийн солбицол

№	Өргөрөг	Уртгаг
1	47°44'21.22"N	107°16'27.45"E
2	47°44'21.22"N	107°16'44.67"E
3	47°44'16.72"N	107°16'44.67"E
4	47°44'16.72"N	107°16'27.45"E

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан



Зураг 2 Үйлдвэрийн эдэлбэр газар




Зураг 3 Төсөл хэрэгжих орчны тойм

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан



Зураг 4 Төсөл хэрэгжиж буй талбай



Зураг 5 Төсөл хэрэгжих газрын засаг захиргааны харьяалал

1.1. Үйлдвэрийн хүчин чадал

Налайх дүүрэгт байрлах тэсрэх бодисын үйлдвэр агуулахын цогцолбор нь жилийн дөрвөн улиралд тасралтгүй ажиллах бөгөөд жилдээ 6000 тн энгийн найрлагатай тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадалтайгаар, өдрийн 1 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 9 цагаар ажиллаж байгаа ба энэхүү төслийн тодотголоор хоногт 2 ээлжээр ажиллахаар төлөвлөж байна. Тус үйлдвэр нь цагт 2 тонн энгийн найрлагатай тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадалтай.

1.2. Үйлдвэрлэлийн зориулалттай энгийн найрлагатай тэсрэх бодисын орц, найрлага, түүхий эдийн шинж чанар

“Нитросибирь Монголиа” ХХК нь уг төслийн хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ОХУ-ын

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

дэвшилтэт техник, технологи бүхий үйлдвэрийн шугамыг нэвтрүүлсэн бөгөөд үйлдвэрлэлийн зориулалттай энгийн найрлагатай тэсрэх бодис /АНФО/ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байна.

Үйлдвэрлэлийн зориулалттай энгийн найрлагатай тэсрэх бодис /АНФО/ үйлдвэрлэхэд Аммонийн нитрат /сэвсгэржүүлсэн II маркийн аммиакийн шүү/ болон дизель түлшийг үндсэн түүхий эд болгон ашигладаг.

Энгийн найрлагат тэсрэх бодис үйлдвэрлэх технологи нь манай улсад түгээмэл хэрэглэгдэж буй технологитой ижил бөгөөд үйлдвэрийн тоног төхөөрөмж, удирдлагын систем нь автоматчигсан тул хүний оролцоо харьцангуй бага юм.

Тус үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн болох энгийн найрлагат тэсрэх бодисыг захиалагч байгууллага болон сэрвис үйлчилгээ үзүүлж буй компаниудын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн полиэтилен дотортой уутанд 25 кг-аар савлан нийлүүлдэг юм.

Түүхий эдүүдийг хадгалалтыг стандарт норм, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зориулалтын нөөц агуулахуудад хадгалах бөгөөд бүтээгдэхүүний хадгалалтын горим, хугацааг чанд сахих шаардлагатай юм.

1.2.1. Үндсэн түүхий эд, шинж чанар

Аммонийн нитрат: Аммонийн нитрат нь марк төрлөөсөө хамааран зориулалт нь өөр өөр байдаг ба дараах хүснэгтэд зориулалт ангиллыг үзүүлээ.

Хүснэгт 1. MNS 4747:99 Монгол улсын стандартаар батлагдсан Аммонийн нитрат хэрэглээ зориулалт

№	Шүүний нэр, марк		Хэрэглээ
1	Ердийн мөхлөгт аммонийн нитрат	Марк - А	Эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэхэд ашиглах
2		Марк - Б	Бордооны зориулалтаар болон уурхайн үйлдвэрийн нөхцөлд энгийн тэсрэх бодис бэлтгэх
3	Нүх сүвэрхэг мөхлөгт Аммонийн нитрат	Марк - II	Бордооны зориулалтаар болон уурхайн үйлдвэрийн нөхцөлд энгийн тэсрэх бодис бэлтгэх
4	Сэвсгэржүүлсэн Аммонийн нитрат		Уурхай үйлдвэрийн нөхцөлд энгийн тэсрэх бодис бэлтгэх

Тэсрэх бодисын үндсэн түүхий эд болох ердийн мөхлөгт аммонийн нитратыг нефтийн бүтээгдэхүүнийг шингээх, тогтоон барих шинж чанарыг нэмэгдүүлэх зорилгоор түүнд дулаан-химийн боловсруулалт хийж сэвсгэржүүлэн, нүх сүвэрхэг болгон энгийн тэсрэх бодисын түүхий эдээр ашигладаг.

Ердийн А, Б маркийн мөхлөгт аммонийн нитрат нь 6% - 9%-ийн маш бага нүх сүвтэй тул сольжийн тос зэрэг шингэн бүтээгдэхүүн хэсгийг тогтоон барих чадвар бага (2.0% - 2.5%) байдаг.

Харин II маркийн нүх сүвэрхэг аммонийн нитратыг тэсрэх бодис үйлдвэрлэхэд хэрэглэдэг тул нүх сүв нь 15% - 18% байх ба энгийн тэсрэх бодисын үйлдвэрлэлд II маркийн нүх сүвэрхэг аммонийн нитратыг үндсэн түүхий эдээр ашиглана.

Аммонийн нитрат нь тэсрэх бодисын найрлагад исэлдүүлэгчийн үүрэг гүйцэтгэх бөгөөд аммонийн нитрат болон агаарын холимог нь тодорхой нөхцөлд тэсрэх боломжтой байдаг ба түүний тэсрэлтийн гол үзүүлэлтийг дараах хүснэгтээр үзүүлээ.

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

Хүснэгт 2. Аммонийн нитратын тэсрэлтийн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Байвал зохих хэмжээ
1	Тэсрэлтийн дулаан, ккал/кг	340
2	Хийн төлөвийн бүтээгдэхүүн, л/кг	980
3	Детонацийн хурд, м/с	1500-2500
4	Тэсрэлтийн температур, оС	1550
5	Ажлын чадвар, см ³	165-230
6	Детонаци авах ил цэнэгийн туйлын диаметр, мм	100-300

Аммонийн нитрат-(NH₄NO₃) буюу азотын хүчлийн давс нь O₂-60%, N-35%, H- 5%-ийн нэгдэл юм. Цагаан өнгөтэй талст хэлбэртэй хайлах температур нь 169,6°С-д хайлдаг. Үүнээс их халаахад аажмаар задарч эхэлдэг ба 210°С-д бүрэн задардаг. Детонацийн хурд 2570 м/с.

Хүснэгт 3. Аммонийн нитрат үзүүлэлт

№	Үзүүлэлт	Норм
1	Олон улсын бүртгэлийн дугаар /CAS/	6484-52-2
2	Уусах чанар	190гр/100мл
3	Буцлах хэм	210°С
4	Гадаад төрх, байдал	Цагаан талст хэлбэртэй
5	Үндсэн бодисын агууламж (NH ₄ NO ₃)	99.5%-иас багагүй
6	Сульфжуулсан үнс	0.01%-иас ихгүй
7	pH (5% уусмал)	4.5-6
8	Кальцийн ион (Ca)	0.003%-иас ихгүй
9	Хлорын ион (Cl)	0.0005%-иас ихгүй
10	Нитритийн ион (NO ₂)	0.0005%-иас ихгүй
11	нягт	1.72

Дизель түлш: Дизель түлш нь шатагч шингэний үүрэг гүйцэтгэдэг. Түүний уур болон агаартай найрсан холимогийн тэсрэлт үүсгэх аюултай концентраци нь эзэлхүүнээр тооцоход 2-3% байна.

Зуны түлшний ("Л" марк) өөрөө шатах хэм нь 300°С, өвлийн түлшний ("З" болон "ДЗ" марк) 310°С байна. Ажлын байранд агаар дахь түлшний хийн зөвшөөрөгдөх дээд агууламжийн хэмжээ 300мг/м³-аас бага байх шаардлагатай. Дизель түлш нь аюулын 4- р зэрэгтэй, бага хортой бодисын ангилалд багтдаг.

Дизель түлш нь хүний арьс саласт бүрхэвчийг гэмтээх ба удаан хугацааны туршид арьсанд хүрэлцсэнээс арьсны загатнаа, үрэвсэлийг бий болгож болно.

- Зуны "Л" марк бол доод хязгаар нь 69°С, дээд хязгаар нь 119°С (шатах шингэн)
- Өвлийн "З" болон "ДЗ" марк бол доод хязгаар нь 62°С, дээд хязгаар нь 105°С (хялбар шатах шингэн) байна.

Хүснэгт 4. Дизель түлшний нийтлэг чанарын үзүүлэлт

№	Тодорхойлолт	Дизель түлш	
		"Л" Зуны "З"	"ДЗ" Өвлийн
1	Зуурмагтайн кинетик Температур: 20°С 50 °С	3-6	1.8-3.2
		-	-
2	Нягт 20 °С, кг/м ³	860	830
3	Шатах температур °С	10	35
4	Царцах температур, °С	-10	-35-45
5	Ажлын байр дахь зөвшөөрөгдөх хэмжээ мг/м ³	300	300

1.3. Үйлдвэрийн ажиллах горим, бүтээгдэхүүн гаргалт

1.3.1. Үйлдвэрийн ажиллах горим

Үйлдвэр нь хоногт 1 ээлжээр ажиллах бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа нь 9 цаг байна. Үйлдвэр нь төлөвлөгөөт засвар үйлчилгээ болон бүх нийтээр амардаг баяр ёслолын хоног зэргийг тооцон жилдээ 226 хоног бодитоор ажилладаг бөгөөд сард ажиллах бодит хоног 20 байна.

Хүснэгт 5. Энгийн тэсрэх бодисын үйлдвэрийн хүчин чадал, ажлын горим

№	Тодорхойлолт	Дүн
1	Хуанлийн хоног	365
2	Зогсолт	104
3	Төлөвлөгөөт засварын хоног	10
4	Урсгал засварын хоног	5
5	Баяр ёслолын хоног	13
6	Цаг агаарын саатал	7
7	Жилд ажиллах бодит хоног	226
8	Ээлжийн тоо	2
9	Хоногт ажиллах нийт цаг	9
10	Цаг ашиглалтын коэффициент	0.8
11	Жилд ажиллах бодит цаг	4068
12	Сард ажиллах бодит цаг	135
13	Жилийн хүчин чадал тн/жил	6000
14	Хоногийн хүчин чадал тн/хоног	26.5
15	Цагийн хүчин чадал тн/ц	1.8-2.0

Үйлдвэр нь даваагаас баасан гаригийн хооронд буюу долоо хоногийн ажлын 5-н өдөр нэг ээлжээр, ээлжинд 9 цаг ажиллаж байна. Үйлдвэр нь хагас бүтэн сайнд амрах бөгөөд жилд нийт 104 хоног амарна. Гэнэтийн хүчин зүйлийн улмаас тэсрэх бодисын үйлдвэрлэлийг тодорхой хугацаагаар зогсоох тохиолдолд уг алдагдсан хоногуудыг амралтын өдрөөр нөхөж ажиллах зохицуулалтыг үйлдвэрийн захиргаа бүтээгдэхүүний захиалгаас хамааруулан зохион байгуулна.

Уг ТЭЗҮ-ийн тодотголоор үйлдвэр нь суурилагдсан хүчин чадалдаа бүрэн хүрч жилд 6000 тонн тэсрэх бодис үйлдвэрлэх зорилго тавин ажиллана. Үүний тулд үйлдвэр нь долоо хоногийн ажлын таван өдөр 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 9 цаг байхаар зохицуулалт хийн ажиллана.

1.3.2. Бүтээгдэхүүн гаргалт

Уг үйлдвэр нь жилдээ 6000 тн энгийн найрлагатай тэсрэх бодис /АНФО/ үйлдвэрлэн харилцагч байгууллагууддаа нийлүүлэх бөгөөд өмнөх онуудын захиалгат бүтээгдэхүүний хэмжээнээс харахад тэсрэх бодисын эрэлт их байгаа ба жилд үйлдвэрлэх бүтээгдэхүүнийг борлуулах зах зээл хангалттай харагдаж байна.

Энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр нь Монгол улсын MNS 4223 стандартын дагуу энгийн найрлагат тэсрэх бодис үйлдвэрлэх бөгөөд шаардлагатай хольцын хэмжээг жил тус бүрээр үзүүллээ.

Хүснэгт 6. Тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ жил бүрээр

№	Бүтээгдэхүүн	Ашиглалтын жил					Нийт
		1	2	3	4	5-10	
1	Тэсрэх бодис /АНФО/	6000	6000	6000	6000	36000	60000

Энгийн найрлагатай тэсрэх бодис: Уг тэсрэх бодисын орц найрлагын 94%-ийг аммонийн нитрат, 6%-ийг дизель түлш тус тус бүрдүүлэх бөгөөд уг тэсрэх бодисын тэсрэлтийн хүч, хурд бага тул зөөлөн, дунд зэргийн хатуулагтай чулуулагт усгүй хуурай орчинд ашиглана.

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

Хүснэгт 7. Энгийн найрлагатай тэсрэх бодисын орц найрлага

№	Түүхий эдийн нэр	Орц %	1000 кг тэсрэх бодисонд орох хэмжээ
1	Аммоний нитрат	94	940
2	Дизель түлш	6	60
3	Нийт	100	1000

Энгийн найрлагатай /АНФО/ нэр төрлийн тэсрэх бодис нь сүвэрхэг аммонийн нитрат, дизель түлшний хольцоос бүрдсэн тэсрэх бодис бөгөөд ил болон далд уурхай, хуурай болон усгүйжүүлсэн цооногт хийж тэслэхэд тохиромжтой. Үндсэн цэнэгээр ашиглагддаг бөгөөд өдөөгч ТБ-оор тэсэрдэг.

Уг тэсрэх бодисыг 2 давхар уутанд 25 кг-аар савалсан байдалтай байдаг тул цэнэглэгч машин хүрч очих боломжгүй аль эсвэл харьцангуй бага хэмжээний тэсэлгээ хийх үед ашиглахад тохиромжтой.

Хүснэгт 8. Энгийн найрлагат тэсрэх бодисын чанарын үзүүлэлт

№	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Үзүүлэлт	MNS 4223:94
1	Номиналь нягт	г/см ³	0.82	0.8-1.0
2	Тэсрэлтийн дулаан	(кДж/кг)	3700	3800-4100
3	Харьцангуй чадал	%	100	-
4	Номиналь детонацийн хурд	м/с	2500-4500	2200-2800
5	Олгойн диаметр	мм	76, 101, 127	120-160
6	Хадгалах хугацаа	сар	2	-

Тэсрэх бодисын үйлдвэрийн жилд шаардлагатай түүхий эдийн хэмжээг тэсрэх бодисын орц найрлагаас хамааруулан дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 9. Үйлдвэрлэлийн 1 жилд шаардлагатай түүхий эдийн хэмжээ

№	Түүхий эдийн нэр	Орц, %	Жилийн хэрэглээ, тн
1	Энгийн найрлагатай тэсрэх бодис		
1.1	Аммонийн нитрат	94	5640
1.2	Дизель түлш	6	360
1.3	Дүн	100	6000

Эндээс харахад 6000 тн энгийн найрлагат тэсрэх бодис үйлдвэрлэхэд аммонийн нитрат 5640 тн, дизель түлш 360тн шаардлагатай байна.

Эдгээр түүхий эдийг урд хөрш Хятад улсаас импортоор оруулж ирж үйлдвэрт тээвэрлэгдэн ирж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглагддаг.

Түүхий эдийг нэг удаагийн татан авалт нь агуулахын багтаамжаас хэтрэхгүй байх бөгөөд уг үйлдвэрийн түүхий эдийн агуулах нь хамгийн ихдээ 120 тн аммонийн нитрат хүлээн авах багтаамжтай бөгөөд дизель түлш хадгалах савны багтаамж 2 тн, тэсэлгээний хэрэгслийн агуулахын багтаамж нь мөн адил 120 тн багтаамжтай барьж байгуулсан байна.

Хүснэгт 10. Түүхий эдийн хэрэглээ /ашиглалтын жилээр/

№	Түүхий эд	Орц, %	Ашиглалтын жил				
			1	2	3	4	5-10
1	Тэсрэх бодис АНФО	100	6000	6000	6000	6000	36000
1.1	Аммонийн нитрат, тн	94	5640	5640	5640	5640	33840
1.2	Дизель түлш, тн	6	360	360	360	360	2160
2	Нийт тэсрэх бодис, тн	100	6000	6000	6000	6000	6000


1.4. Үйлдвэрлэлийн технологийн шат дамжлага

Энгийн тэсрэх бодисын үйлдвэр нь Аммиакийн шүүний бункер, холигч шнек, түлш хангамжийн систем, нэмэгдэл хольцын бункер, уутлан савлах болон уутны амыг оёх зэрэг иж бүрэн автомат

хяналтын системтэй байна.

Энгийн тэсрэх бодис бэлтгэх зориулалт бүхий сэвсгэржүүлсэн аммиакийн шүүг дизелийн түлшний хамт 94:6 гэсэн харьцаагаар технологийн дагуу хольж энгийн тэсрэх бодисыг үйлдвэрлэх бөгөөд уутлан савалсан байдлаар бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ.

Аммиакийн шүү болон нефтийн бүтээгдэхүүнийг холих механик шнек тодорхой өгөгдлөөр эргэлдэж байхад шнект суурилагдсан дизель түлшний тоосруулагч нь дизель түлшний насосын эргэлтээр тохируулсан хэмжээгээр аммиакийн шүүнд дизель түлшийг сууринд бэхэлсэн жингийн автомат мэдрэгч нь савалгааны үндсэн өгөгдөлд хүрэхэд автоматаар шнекийн ажиллагааг зогсоодог байна. Тус үйлдвэрийн хувьд 25 кг-аар тохируулга хийн савалдаг юм. Дизель түлшний насосын эргэлт нь бүтээгдэхүүний орцыг тохируулж өгдөг бол жингийн өгөгдөл нь бүтээгдэхүүний савалгааны хэмжэг тохируулдаг. Эдгээр тохируулгын удирдлагууд нь үйлдвэрийн хананд бэхлэгдсэн 2 шкафт суурьлагдсан байна.



Зураг 1. Энгийн тэсрэх бодис /АНФО/ үйлдвэрлэх технологийн бүдүүвч

Энэ тэсрэх бодис нь тэсрэлтийн хүч, хурд бага тул зөөлөн, дунд зэргийн бат бэхтэй чулуулагт хуурай нөхцөлд хэрэглэхэд тохиромжтой. Уг бодисыг аммиакийн шүү - ($\text{NH}_4 \text{NO}_3$), дизель түлш болон бусад нэмэгдэл хольцыг холих замаар гарган авдаг ба ил уурхайд тэсэлгээ хийхэд мөн хад чулуу бутлахад ашигладаг. Уг бодис нь ус үл нэвтрэх чанарын хувьд тийм ч сайн биш учир устай орчинд хэрэглэвэл усанд угаагддаг сул талтай юм.

Үйлдвэрлэлийн зориулалттай энгийн найрлагат тэсрэх бодисын үйлдвэрлэлд олон улсын практикт өргөнөөр ашиглаж буй ОХУ-ын технологи бүхий иж бүрэн тоног төхөөрөмж УЗА-1 маркийн үйлдвэрийг нэвтрүүлэн ашиглаж байгаа бөгөөд техникийн үзүүлэлтийг дараах хүснэгтэд үзүүллээ.

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан



Хүснэгт 11. Тэсрэх бодисын УЗА-1 маркын үйлдвэрийн техникийн үзүүлэлт

№	Тодорхойлолт	Үзүүлэлт
1	Үйлдвэрийн хүчин чадал	2 тн/цаг
2	Ажиллагаа	Аюулгүй байдал бүрэн хангасан
3	Бункерийн багтаамж, кг	50
4	Суурин үйлдвэрийн хэмжээ	20тн контейнер
5	Шнекийн хөдөлгүүрийн чадал, кВт	4
6	Дизель түлш өгөх насосны чадал, кВт	2.2
7	Савлах төхөөрөмж, тн/ц	2.2
8	Бүрэлдэхүүн хэсгийг холих хугацаа, сек	30
9	Дизель түлшний бакийн багтаамж, литр	2000



Зураг 2. Энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх суурин тоног төхөөрөмжийн схем


Тайлбар: Аммиакийн шүүний бункер-1, Холигч шурган дамжуулагч-2, Савлагч тоног төхөөрөмж-3, Дизель түлшний бункер болон шахах насос-4, Автомат хяналтын самбар-5




Зураг 3. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт /бодит байдал/

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

УЗА-1 маркийн үйлдвэрийн тохиргоог анх туршилтанд оруулахад хийх ба ер нь байнга өөрчлөх шаардлага байдаггүй ба ховор тохиолдолд сардаа нэг удаа хийдэг. Энэ тохиргоо нь үйлдвэрийн дизель түлшний насосын эргэлтийг үйлдвэрлэх бүтээгдэхүүний хольцын найрлагыг тааруулах ажиллагаа юм.



Зураг 4. Нефтийн бүтээгдэхүүний насосны эргэлтийн давтамж тохируулах самбар



Зураг 5. Савалгааны жингийн тохируулгын самбар

1.4.1. Аммиакийн шүү хүлээн авах бункер

Үйлдвэрийн байртай зэргэлдээ орших түүхий эдийн агуулахаас ирсэн полиэтилен савалгаатай аммонийн нитратыг задлан 50 кг багтаамжтай хүлээн авах бункерт тэжээнэ.


Аммонийн нитрат нь хадгалалт тээвэрлэлтийн норм, горим зөрчигдснөөс үүдэн чийг авч тодорхой хэсэг нь бөөнцөг үүсгэн бүхэллэг болсон байх тул хүлээн авах бункерийн доор 4мм-ийн сараалжин тор байрлуулж бүхэллэгийн хяналтыг хийх бөгөөд нарийн ширхэглэл бүхий аммонийн нитрат нь уг тороор нэвтрэн шурган дамжуулагчид өгөгдөнө.

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

Энгийн найрлагатай тэсрэх бодис үйлдвэрлэх үндсэн түүхий эдийн нэг болох дизель түлш нь аммиакийн шүү хүлээн авах бункерийн дэргэд 2 тонн багтаамжтай тусгай зориулалтын саванд /ёмкость/ хадгалаатай байрлана.

Хүснэгт 12. Аммонийн нитрат хүлээн авах бункерүүдийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжээ
1	Аммиакийн шүүний бункер	
1.1	Багтаамж, кг	50
1.2	Урт*өргөн*өндөр, м	1.2*1.2*0.9
1.3	Торны нүхний хэмжээ, мм	40



1.4.2. Холигч шурган дамжуулагч

Анхдагч үндсэн түүхий эд хүлээн авах бункерийн доод хэсэгт холигч шурган дамжуулагч байрлах бөгөөд аммонийн нитрат болон дизель түлшийг тодорхой орц найрлагын дагуу тогтмол жигд хурдтайгаар хольж эцсийн бүтээгдэхүүн энгийн найрлагат тэсрэх бодис үйлдвэрлэх бөгөөд аммонийн нитратын хэмжээнээс хамааруулан дизель түлшийг шахаж өгнө. Үйлдвэрлэлийн хүчин чадлыг энэхүү шурган дамжуулагчийн тусламжтайгаар удирдан явуулах бөгөөд шурган дамжуулагч нь 150 мм- ийн диаметртэй зэвэрдэггүй ган хоолой бүхий төхөөрөмж юм.

Уг шурган дамжуулагч нь 1 минутад 0.2 тн бүтээгдэхүүнийг шилжүүлэх суурилагдсан хүчин чадалтай бөгөөд ачааллыг нь тохируулах хяналтын самбар нь тэжээлийн бункерийн дэргэд байрлана. Хянах самбар нь яаралтай зогсоох товчлууртай байх ба технологийн горим зөрчигдөх, нэн яаралтай зогсоох шаардлагатай үед уг товчлуур ашиглагдана.

Хүснэгт 13. Шурган дамжуулагчийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжээ
1	Бүтээл, кг/мин	150-250
2	Шнекийн диаметр, мм	150
3	Шнекийн урт, мм	2600
4	Хөдөлгүүрийн чадал, кВт	4
5	Шнекийн эргэлтийн тоо, эрг/мин	945




1.4.3. Дизель түлшний шахуурга

Үйлдвэрийн байрны дэргэд байрлах дизель түлшний нөөцийн савнаас тоолууртай насосын тусламжтайгаар түлшийг аммонийн нитратын хэмжээ, тэсрэх бодисын үйлдвэрлэлийн хэмжээнд тохируулан шурган дамжуулагчийн хажуугаас шахаж өгөх бөгөөд нэг удаагийн үйлдвэрлэлд шаардлагатай түлшний хэмжээний тоон утгыг удирдлагын самбарт оруулж өгнө. Шахуургын насос болон түүний соролтын болон шахалтын шланкуудын битүүмжлэлийг ээлж эхлэхийн өмнө тогтмол шалгаж, ажлын байрны үзлэгийг хийж байх шаардлагатай.

Хүснэгт 14. Түлш шахах насосны техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжээ
1	Насосны хүчин чадал кВт	2.2
2	Бүтээл л/цаг	310
3	Сорох диаметр мм	45
4	Шахах диаметр мм	32



1.4.4. Бүтээгдэхүүн савлах хэсэг

“Нитросибирь Монголиа” ХХК нь харилцагч байгууллага, хэрэглэгчийн захиалгын дагуу эцсийн бүтээгдэхүүн энгийн найрлагатай тэсрэх бодисыг шуудайлах болон зарим онцгой тохиолдолд

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

бортогolon савлах юм.

Шурган дамжуулагчаар холигдож бэлэн болсон энгийн найрлагатай тэсрэх бодис нь бэлэн бүтээгдэхүүний бункерт өгөгдөх бөгөөд бункер нь доороо эсрэг жин бүхий савлалтын хэмжээ тохируулгагч бүхий хавхлагатай байна.

Хавхлагийн эсрэг жинг шуудайлах бүтээгдэхүүний жингээс бага буюу тэнцүү хэмжээгээр тохируулах бөгөөд шуудайлж буй тэсрэх бодисын хэмжээ шаардлагатай хэмжээнд хүрмэгц жингийн автомат мэдрэгч нь автоматаар шнекийн ажиллагааг зогсоодог. Тус үйлдвэрийн савалгааны жингийн өгөгдлийг 25 кг-аар тохируулсан.

Савлагдсан тэсрэх бодисыг ам оёх хэсэг рүү шилжүүлэх бөгөөд гар ажиллагаатай ам үдэгч машины тусламжтайгаар амыг оёж эцсийн бэлэн бүтээгдэхүүн бий болно.



Зураг 6. Бүтээгдэхүүн савлах болон ам оёх хэсэг /бодит байдал/

1.4.5. Аммиакийн шүү болон тэсрэх бодисын агуулах хооронд шилжүүлэх ажиллагаа

Аммиакийн шүүг агуулахаа үйлдвэрийн хэсэг рүү, савлагдсан тэсрэх бодисыг үйлдвэрээс бүтээгдэхүүний агуулах руу зориулалтын модон подон дээр өрөн өргөж шилжүүлэх ажлыг Toyota FDZN30 маркийн 3 тн ачаа өргөх хүчин чадал бүхий сэрээт өргөгчөөр гүйцэтгэнэ.

Хүснэгт 15. Сэрээт өргөгчийн техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Өргөх даац	Кг	3000
2	Жин	Кг	3100
3	Хурд	Км/цаг	19
4	Их бие Урт*өргөн*өндөр	Мм	2770*1255*2195
5	Өргөх хамгийн их өндөр	Мм	3000
6	Хөдөлгүүрийн чадал	кВт	33



Уг сэрээт өргөгчийг 2018 онд төсөл хэрэгжүүлэгч өөрийн хөрөнгөөр авч ашиглаж байгаа ба төслийн хөрөнгө оруулалт хэсэгт хуримтлагдсан элэгдлийг хасаж үлдэгдэл өртгөөр тооцож авлаа. Тус үйлдвэрийн жилийн хүчин чадал 6000 тн байх ба сэрээт өргөгч нь жилд үйлдвэрлэх тэсрэх бодисыг агуулах хүртэл тээвэрлэх, агуулахаас түгээлтийн машинд ачих зэрэг ажилд бүрэн хүрэлцээтэй байдаг байна.

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

1.5. Үйлдвэрийн барилга байгууламж


Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр агуулахын цогцолбор нь аммиакийн шүүний агуулах, үйлдвэрийн байр, бүтээгдэхүүний агуулах, тэсрэх материалын агуулах, оффис, хоолны газрын барилга, түлш хадгалах цэг, лаборатори, туршилтын талбай, хамгаалалтын хашаа пост зэргээс бүрдэнэ. Тус барилга байгууламжуудыг “Нитросибирь Монголиа” ХХК нь 2015 онд өөрийн хөрөнгөөр барьж байгуулан ашиглалтанд оруулсан байна.



Зураг 7. Үйлдвэр агуулахын цогцолбор харагдах байдал

1.5.1. Энгийн найрлагат тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын барилга, түлшний сав

Тэсрэх бодисын үйлдвэр агуулахын барилгууд нь тусгай зориулалтаар тоногдолсон 20-40 тн багтаамж бүхий контейнерүүд байна. Энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэрийн барилга нь УЗА-1 тоног төхөөрөмжийг бүрэн байршуулсан 20 тн багтаамжтай контейнер байна.



Зураг 8. Тэсрэх бодисын үйлдвэрийн барилга /бодит байдал/

Түүхий эдийн агуулахын хэсэг: Түүхий эдийн /Аммиакийн шүү/ агуулах нь 12.5х2.5 м төмөр хийц бүхий өндөр нь 2.5 м хэмжээтэй дотроо хүчитгэсэн бетон ханаар тусгаарлагдсан тусгай зориулалтын 4ш контейнер байрлуулсан байна. Тус контейнерүүдийн үүд нь зүүн зүгт харсан байрлалтай байх ба уг түүхий эдийн агуулах нь тэсрэх бодисын үйлдвэрээс урагш 20 м зайд барьж байгуулсан байна.

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

Түүхий эд болох аммонийн нитрат нь чийг авч болохгүй учир агуулахын дээврийг бороо уснаас хамгаалсан налуу суурилуулсан төмөр дээврээр хамгаалсан байна. Аммиакийн шүүний агуулах нэг бүр нь 15 тн, нийт 60 тн аммиакийн шүүг хадгалах хүчин чадалтай юм.

Агуулахад одоогийн байдлаар 40 кг-ийн савалгаатай нүх сүвэрхэг аммиакийн шүү хүлээн авч байгаа бөгөөд нэг модон тавцан дээр 25 шуудай буюу 1 тн хэмжээтэйгээр ам дарах байдлаар өрж сэрээт ачигчаар тээвэрлэх боломжтой болгон хураана.




Зураг 9. Аммиакийн шүүний агуулахын харагдах байдал

Үйлдвэрлэлийн хэсэг: Бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэсэг нь түүхий эдийн агуулахын хойд талд байрлалтай болон 12.2 x 2.5 м харьцаа бүхий контейнерэн барилга юм. Барилгын төв хэсэгт энгийн тэсрэх бодис үйлдвэрлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд байрлах ба үйлдвэрийн агааржуулалтыг байгалийн аргаар байж болохуйц хоёр талдаа онгорхой байхаар зохион байгуулсан ба гэрэлтүүлгийг ажлын байрны хэвийн нөхцөлд тавигдах шаардлага стандартын дагуу иж бүрнээр хийж тоноглогсон байна. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хэсгийн анхааруулах шар зураасаар хүрээлэн тогтоож улмаар барилгын гарах гарцны дэргэд болон тоног төхөөрөмжүүдийн ойролцоо гал унтраах хэрэгслүүдийг авч хэрэглэхэд саадгүйгээр байрлуулсан байна. Үйлдвэрийн хэсэгт 1 удаагийн үйлдвэрлэлээс гарах тэсрэх бодисын хэмжээ нь 1 тн бөгөөд үүнийг модон тавцан дээр ам дарах байдлаар хураан сэрээт ачигчаар агуулах руу тээвэрлэнэ. Үйлдвэрийн байр нь хүйтний улиралд даконы цахилгаан зуухаар халаана.

Үйлдвэрлэлийн явцад үйлдвэрийн байрны доторх агаарын цэвэр байлгах, аммонийн нитратын эхүүн үнэрийг дарах, хий тоосны аюулгүй байдлыг хангах үүднээс аммонийн нитратын болон тэсрэх бодисын үйлдвэрийн агаарын урсгалыг чөлөөтэй байхаар хангах бөгөөд үйлдвэрийн байрны агаарыг сорох вентляторын тусламжтайгаар гадагшуулах замаар агаарын сэлгэлтийг байнга хийнэ.

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан



Зураг 10. Үйлдвэрийн дотор хэсэг

Бүтээгдэхүүний агуулахын хэсэг: Энгийн тэсрэх бодис хадгалах түр агуулах нь 12.2x2.5 харьцаа бүхий талбайтай, 20 тн 8 ширхэг контейнер байгаа бөгөөд үйлдвэрээс гарч буй савласан бүтээгдэхүүнийг 1 тн хэмжээтэйгээр нь модон тавцан дээр хурааж сэрээт ачигчаар өргөн тус агуулахад байршуулна.

Агуулах болон үйлдвэрийн хоорондын тусгаарлах ханыг 0.3 м зузаан хүчитгэсэн бетоноор хийсэн байна. Тус агуулах нь хэдийгээр 120 тн энгийн тэсрэх бодис нэгэн зэрэг хүлээн авах хүчин чадалтай хэдий боловч үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн захиалгаас хамаарч байдаг тул хамгийн ихдээ үйлдвэрийн 2 хоногт үйлдвэрлэх бүтээгдэхүүн буюу 50 тн тэсрэх бодис байршуулдаг байна.



Зураг 11. Бүтээгдэхүүний агуулахын харагдах байдал

Түлш хадгалах сав: Бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашиглах дизель түлшийг үйлдвэр агуулахын барилга дотор байрлуулсан түлш хадгалах савнаас үйлдвэрлэлийн шугам руу технологийн шугам хоолойгоор шууд холбосон байна.

Түлш хадгалах сав нь 2 тн багтаамжтай 1 ширхэг ёмкость байгаа бөгөөд нарны шууд халалт, гадны нөлөөллөөс хамгаалах шаардлагатай тул үйлдвэрийн барилгын дотор буюу контейнер байршуулсан байна. Мөн түлш хадгалах савны гадуур галын аюултай, шатамхай бодис, ил гал гаргахыг хориглоно

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан


гэх мэт зохих анхааруулах, хориглох тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан нь түлш хадгалах хэсгийг гадны аюултай нөлөөллөөс бүрэн хамгаалсан байна гэж үзэж байна.



Зураг 12. Түлш хадгалах савны харагдах байдал

1.5.2. Тэсрэх материал хүлээн авах, түгээх байр, лаборатори

Үйлдвэрийн дэргэд тэсрэх бодисын найрлага, чанарт хяналт тавих зорилгоор үйлдвэрийн шат дамжлага дахь завсрын бүтээгдэхүүн болон эцсийн бүтээгдэхүүнээс дээж авч шинжлэх лабораторитой байх бөгөөд лабораторийн өрөө нь шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байна. Лабораторийн өрөө болон тэсрэх бодис, тэсрэх хэрэгслийг хүлээн авах, олгох зориулалт бүхий өрөөнүүд хамтдаа нэг байранд байхаар төлөвлөгдсөн байна. Тус байр нь 9x6 м хэмжээтэй сэндвичэн барилга байна.



Зураг 13. Лаборатори болон тэсрэх материал хүлээн авах, түгээх байрны дотоод зохион байгуулалт


Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан



Зураг 14. Лаборатори болон тэсрэх материал түгээх байр /бодит байдал/

1.5.3. Шалган нэвтрүүлэх постын барилга

“Нитросибирь Монголиа” ХХК-ийн Налайх дүүрэгт орших тэсрэх бодисын үйлдвэрлэлийн бүсийн аюулгүй байдлыг хангах үүднээс дотогш нэвтэрч байгаа ажиллагсад болон зочдын бичиг баримтыг шалгах, бүртгэл хөтлөх, гал гаргах хэрэгсэл, гар утас, холбооны хэрэгсэл, зэвсэг гэх мэт хорiotой зүйлсийг түр хураах үндсэн үүрэг бүхий төв шалган нэвтрүүлэх пост ажиллах бөгөөд үүнээс гадна, үйлдвэрийн бүсэд нэвтрэх шалган нэвтрүүлэх хэсэг, харуулын өндөрлөсөн постууд мөн ажиллана. Тэсэрч дэлбэрэх аюултай бодис үйлдвэрлэдэг, хадгалдаг объект учир байнгын мэргэжлийн харуул хамгаалалтай байх нь гадны халдлага болон аливаа эрсдэл зэргээс урьдчилан сэргийлэх боломжийг бий болгоно.



Зураг 15. Үйлдвэрийн шалган нэвтрүүлэх болон харуулын пост

1.5.4. Хамгаалалтын хашаа, бусад тоноглолууд

Үйлдвэрийн эдэлбэр талбайн эргэн тойронд гадны хүн амьтан зөвшөөрөлгүй зорчихоос сэргийлсэн төмөр хашаагаар хүрээлсэн бөгөөд үйлдвэр, агуулахын барилгууд нь мөн давхар хашаан дотор байрлана. Хамгаалалтын хашааны өндөр нь дүрмийн дагуу 2м өндөртэй дээрээ өргөст тортойгоор хийгдсэн байна. Хамгаалалтын хашааны торон дээр тэсэрч дэлбэрэх аюултай гэсэн ойлгогч бүхий тэмдэглэгээг хийсэн байна. Мөн үйлдвэрийн бүсийн талбайг бүрэн гэрэлтүүлж байхаар тооцоологдсон өндөр хүчин чадлын гадаад гэрэлтүүлэг, хяналтын камерын системээр бүрэн тоноглогдсон байна. “Нитросибирь Монголиа” ХХК-ийн хамгаалалтын нэгдсэн бодлогын хүрээнд салбаруудын хяналтын камерыг төв оффисоос бүрэн хянах боломжтойгоор шийджээ. Хяналтын

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

камер болон гэрлүүд нь нэг чигт харсан байрлалтай байх бөгөөд энэ нь камерын тусгалд гэрэл тусч харагдах орчин бүдгэрэхээс сэргийлсэн арга хэмжээ юм.

Хүснэгт 16. Хяналтын камеруудын байршил

№	Камерын байршил	Нийт тоо
1	Шалган нэвтрүүлэх пост болон харуулын цамхагууд тус бүр дээр	2
2	Үйлдвэрийн хашаан доторх 4-н ширхэг цамхаг тус бүр дээр	4
3	Хамгаалалтын хашааны булан бүрт	5
4	Нийт камерийн тоо	11

Хүснэгт 17. Гадаад хяналтын камерийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Утга
1	Марк	NC-130G
2	Нягтрал	480TV lines
3	Харах өнцөг град	75 град
4	Дуран мм	3.6-12
5	Тусгал м	20-100
6	Ажиллах орчин °C	-50 ~ +50
7	Тэжээл	~ 12V
8	Орчны чийгшил %	0-90

Үйлдвэрийн гадна талбайг шөнийн цагт бүрэн гэрэлтүүлж байх шаардлагатай бөгөөд тус үйлдвэрийн хувьд үйлдвэрийн хашааг дагуулан хоорондоо 50 м зайтай байхаар бодож 400 Вт-ын гэрлүүдийг байрлуулсан бөгөөд мөн үйлдвэр болон агуулахуудын хооронд 4 ширхэг өндөр цамхаг байрлуулан мөн гэрэлтүүлгийг тавьсан байна. Энэ нь үйлдвэрийн орчин бүхэлдээ гэрэлтэй байх боломжийг бүрдүүлж өгчээ.

Хүснэгт 18. Гадна гэрэлтүүлгийн лампны үзүүлэлт

№	Үзүүлэлт	Утга
1	Марк	04LTYGTH220B
2	Хүчдэл В	220
3	Гэрэлтэлт Лк	15
4	Лампны чадал Вт	400



Хүснэгт 19. Гадна гэрэлтүүлгийн тоо

№	Гэрэлтүүлгийн байршил	Нийт тоо
1	Үйлдвэрийн хашаан доторх цамхагууд дээр тус бүр 2 ш	4
2	Хашааны дагуух гэрлийн шонгуудад	13
3	Нийт гэрэлтүүлгийн тоо	17

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан



Зураг 16. Үйлдвэрийн хамгаалалтын байгууламжууд

1.5.5. Галын аюулгүйн тоноглолууд

Үйлдвэрийн бүсэд галд мэдрэмтгий, шатах дэлбэрэх аюултай химийн гаралтай бодисууд их хэмжээгээр хадгалагдаж байгаа тул галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын үед хэрэглэх аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон байх шаардлагатай юм. Уг үйлдвэрийн хувьд үйлдвэр агуулахын байруудыг галын дохиоллын системээр бүрэн тоноглогдсон байх бөгөөд гал гарсан тохиолдолд үйлдвэрийн удирдлагын байр болон харуулын байрууд, төв оффист мэдээлэл дамжихаар зохион байгуулсан байна. Үйлдвэр болон агуулахын дотор, гарах гарц бүрийн дэргэд гал унтраагууруудыг байрлуулах бөгөөд тэдгээрийн даралт, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж байх шаардлагатай юм. Мөн үйлдвэр агуулахын гадна талд хаалганаас 20 м-ээс холгүй зайд бүрэн тоноглол бүхий галын сарааг байрлуулсан байна.


Хүснэгт 20. Гал унтраах хэрэгслийн байршил, тоо хэмжээ

№	Галын хэрэгслийн нэр	Байршил	Тоо ширхэг
1	Галын сараа /багц/	Үйлдвэр агуулахын барилгын гадна хаалганаас 20 м зайд	1
2		Түлш хадгалах савны дэргэд	1
3		Оффис хоолны газрын урд харуулын постны дэргэд	1
4		Үйлдвэрийн дэргэд байрлах Тэсэлгээний хэрэгслийн агуулах тус бүрийн дэргэд	3
5		Үйлдрийн барилга дотор, хаалганы дэргэд	2
6	Галын хор /5-8 л/	Түүхий эдийн агуулах дотор, хаалга тус бүрийн дэргэд	4
7		Бүтээгдэхүүний агуулахын хаалганы дэргэд	2
8		Оффис болон гал тогооны өрөөнд тус бүр	2

Үйлдвэр болон агуулахын барилгын таазанд ойролцоогоор 40 м² талбай тутамд 1 ширхэг дулаан мэдрэгч байхаар бодож WIZMART брендийн WMT-12v-A18 маркийн дулаан мэдрэгчүүдийг байрлуулсан байх бөгөөд эдгээр нь тухайн орчны температур тодорхой тохируулсан температураас /+40/ дээшлэхэд дуут дохиолол өгөх бөгөөд мөн төв серверт мэдээлэл дамжуулна.

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

Хүснэгт 21. Утаа мэдрэгчийн үзүүлэлт


№	Үзүүлэлт	Утга	
1	Марк	WMT-12v-A18	
2	Ажиллах температур °C	100-500	
3	Тэжээл В	12	
4	Гүйдэл мкА	160	
5	Орчны чийгшил %	0-95	



Зураг 17. Үйлдвэрийн галын аюулгүйн хэрэгслүүд

1.5.6. Үйлдвэрийн ажилчдын оффис, хоолны газар

Үйлдвэрийн удирдлагын байр болон хоолны газар нь 6х4 хэмжээ бүхий сэндвичэн хийцтэй 2 давхар барилга бөгөөд энд үйлдвэрийн ИТА нар сууж ажиллах оффис, ажиллагсдын хоолны газар, үйлчилгээний машинуудын автогражууд байрлана. Тус барилга нь үйлдвэр агуулахын байрнаас 170 метрийн зайтай байрлаж байна.



Зураг 18. Ажиллагсдын оффис, хооллох байрны дотоод зохион байгуулалт, гадаад харагдах байдал

1.5.7. Үйлдвэрийн аянгын хамгаалалт

Үйлдвэрийн барилга байгууламжуудад аянгын хамгаалалтын системийг инженерийн тооцооллын дагуу найдвартай хийж гүйцэтгэх нэн шаардлагатай байдаг. Налайхын тэсрэх бодисын үйлдвэрийн хувьд үйлдвэр агуулахын байр, оффис, тэсрэх бодис болон тэсэлгээний хэрэгслийн агуулах зэрэг байгууламжуудад канатан аянга хүлээн авагчийг байрлуулсан бөгөөд жил бүрийн 5-р сард эсэргүүцлийг мэргэжлийн байгууллагаар хэмжүүлэн дүгнэлт гаргуулж, хяналт хийдэг байна. Бид

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

тус аянга хамгаалалтын байгууламжуудын үзүүлэлтүүдэд тулгуурлан хяналтын тооцоолол хийж үзсэн бөгөөд уг аянга зайлуулагчууд нь тухайн объектуудыг бүрэн хамгаалж чадахаар тооцоо гарсан.



Зураг 19. Үйлдвэрийн болон агуулахуудын аянга хүлээн авагчийн харагдах байдал

1.5.8. Тэсрэх бодисын туршилтын талбай

Үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүнийг /тэсрэх бодис/ зориулалт бүхий тусгайлан зассан далан болон хашаагаар хязгаарлагдсан газрын гадаргаас өндөрлөсөн талбайг байгуулах зайлшгүй шаардлагатай юм. Энд тэсрэх бодисын чанар, тэсрэлтийн хүч зэргийг тодорхойлох туршилтын бага хэмжээний тэсэлгээ хийгдэнэ. Иймд энэ нь тухайн үйлдвэрийн бүс дэх онцгой объектуудын нэг юм.

Тэсрэх бодисын чанарыг шалгах туршилтын талбай нь үйлдвэрээс баруун хойд тийш 210м –ийн зайд 0.04 га талбайд байгуулсан байна. Тус объект нь дараах байдалтай байна.



Зураг 20. Туршилтын талбайн харагдах байдал

Налайх дүүрэг 3-р хороонд байрлах Нитро Сибирь Монголиа ХХК-ийн “Тэсрэх бодис үйлдвэр агуулахын цогцолбор” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан

1.6. Түүхий эд, туслах материал, хог хаягдал

1.6.1. Төсөлд ашиглах түүхий эд, химийн бодис

Хүснэгт 22. Энгийн найрлагатай тэсрэх бодис үйлдвэрлэхэд ашиглах түүхий эд, орц найрлага

№	Химийн бодисын нэр	Хэмжээ нэгж	Орц, %	Ашиглалтын жил				
				2022	2023	2024	2025	2026-2031
1	Эмульсийн тэсрэх бодис	тн	100	3000	10000	14000	14000	840000
2	Аммонийн нитрит	тн	76.18	2,285.5	7,618.3	10,665.7	10,665.7	63,993.9
3	Ус	тн	16.91	507.3	1,691.0	2,367.5	2,367.5	14,204.7
4	Тиомочевин	тн	0.28	8.3	27.6	38.7	38.7	232.4
5	Дизель түлш	тн	4.12	123.5	411.6	576.2	576.2	3457.4
6	Эмульгатор	тн	1.76	52.9	176.4	247.0	247.0	1481.8
7	Цууны хүчил	тн	0.50	15.0	50.0	70.0	70.0	420.0
8	Натри нитрит	тн	0.25	7.5	25.0	35.0	35.0	210.0

1.6.2. Хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас олборлолтын үеийн болон ахуйн гаралтай хог хаягдал гарна.

Ахуйн хатуу хог хаягдал: Тус үйлдвэр, агуулахад нийт 19 ажилтан ажиллана. Тус төслөөс үүсэх энгийн хог хаягдлын хэмжээг БОАЖ-ын сайдын А/368 тоот тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал”-ын дагуу тооцоолов. Төсөл нь бүрэн хүчин чадлаар ажиллахад хоногт 7.5 кг, сард 225 кг, жилд 2.7 тн хатуу хог хаягдал гарна.

Ахуйн шингэн хаягдал: Үйлдвэр, агуулахын үйл ажиллагаанаас ажилчдын ахуйн шингэн хаягдал гарна. Ахуйн үйл ажиллагаанаас ялгарах шингэн хаягдлын хэмжээг тооцохдоо нийт унд ахуйн усны хэрэглээний 70 % гэж үзэв. Шингэн хаягдлын хэмжээ 1 хоногт 3.15 м³, 1 сард 94.5 м³, 1 жилд 1134 м³ байна.

Хийн хаягдал: Тус төслийн хувьд хийн хаягдал үүсэх эх үүсвэр нь хөдөлгөөнт эх үүсвэр болох тээврийн хэрэгслийн шаталтаас үүсэх утаа, хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ зэрэг болно.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

